



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/658

Булган сум

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын соёл, спортын салбарт онцгой хувь нэмэр оруулсан Булган аймгийн Сайхан сумын уугуул, Монгол Улсын ардын жүжигчин Ц.Төмөрбаатар, Монгол Улсын 3×3 сагсан бөмбөгийн эмэгтэй шигшээ багийн тамирчид Баян-Агт сумын уугуул, Монгол Улсын гавьяат тамирчин О.Хулан болон М.Цэрэнлхам, Б.Ариунцэцэг, Н.Нандинхүслэн нарт улс, аймаг, орон нутгийнхаа нэр хүндийг өндөрт өргөсөн гавьяаг нь үнэлж, хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 5,144,000 (таван сая нэг зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010919

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 16-ны нийгэмдрийн
А/658 дугаар захирамжийн хавсралт

Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	2	3	4	5
1.	Мөнгөн аяга	5ш	380,000	1,900,000
2.	Хадаг	5ш	8,000	40,000
3.	батламж	4ш	21,000	84,000
4.	Айраг	300л	10,000	3,000,000
2.	Айрагны сав	60ш	2,000	120,000
Нийт			5,144,000	